



XII/2021

Тархаасан: 2022 оны 1 дүгээр сарын 12




Улсын хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 27.7 мянга буюу 41.4 хувиар буурчээ

Манай улсын хилээр 2021 оны жилийн эцэст 643.4 (давхардсан тоогоор) мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оноос 672.7 (51.1%) мянгаар буурчээ.

Манай улсын хилээр 2021 онд 323.3 мянган зорчигч орсон байна. Улсын хилээр орсон зорчигчдын 24.7 хувь нь Гашуун сухайт, 16.4 хувь нь Замын-Үүд, 12.1 хувь нь Шивээ хүрэн, 5.7 хувь нь Буянт-Ухаа, 5.2 хувь нь Алтанбулаг, 35.9 хувь нь бусад боомтоор нэвтэрчээ.

Улсын хилээр орсон зорчигчдын 284.1 (87.9%) мянга нь Монгол Улсын иргэд, 39.2 (12.1%) мянга нь гадаад улсын иргэд байна.

ЗУРАГ 1. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ЗОРЧИГЧИД, боомтоор, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцсийн байдлаар



Улсын хилээр 2021 онд гадаадын 39.2 мянган хүн орсон нь өмнөх оноос 27.7(41.4%) мянгаар буурчээ. Тэдний 83.3 хувь нь 30 хүртэл хоног, 2.7 хувь нь 30-аас 90 хүртэл хоног, 14.0 хувь нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар ирсэн байна.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 6.1 (15.6%) мянга нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор, харин 33.1 (84.4%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор ирсэн байна.

Аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оноос 25.8 (43.8%) мянгаар буурсан байна. Өмнөх оноос БНХАУ-ын жуулчид 7 750 (57.4%), ОХУ-ынх 17110 (57.7%), Өмнөд Солонгос Улсынх 2748 (54.3%), Япон Улсынх 754 (66.7%) хүнээр тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААД ЗОРЧИГЧИД, бүс нутаг, улсаар, жил бүрийн эцсийн байдлаар

Бүс нутаг, улсаар	2018	2019	2020	2021
Бүгд	598 406	636 960	66 940	39 236
Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг	372 876	389 581	27 806	12 799
БНХАУ	216 379	208 449	17 340	7 519
БНСУ	86 013	103 379	5 515	2 639
Казахстан	16 381	16 530	1 564	806
Европ	189 161	207 851	35 931	2 054
ОХУ	133 402	146 783	30 980	14 231
Беларусь	2 574	3 299	2 338	4 509
Герман	11 015	12 654	641	560
Америк	25 767	27 174	1 862	2 054
АНУ	18 866	19 948	1 416	1759
Канад	4 481	4 501	320	216
Бразил	792	900	34	20
Өмнөд Ази	3 909	4 381	296	643
БНЭУ	2 572	2 793	236	364
Пакистан	304	337	9	144
Бангладеш	180	201	7	40
Ойрх Дорнод	4 806	5 453	620	1 917
Турк	2 779	1 999	573	1 514
Катар	422	866	11	118
Сири	95	125	2	88
Африк	1 848	2 480	422	401
Өмнөд Африк	1 218	1 764	299	240
Этиоп	67	58	73	47
Морокко	37	36	2	37
Харьяалалгүй	39	37	3	3

Энэ онд улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 38.2 (97.3%) мянга нь насанд хүрсэн хүн, 1071 (2.7%) нь хүүхэд, 34.5 (88.0%) мянга нь эрэгтэйчүүд, 4.7 (12.0%) мянга нь эмэгтэйчүүд байна. Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 54.6 хувь нь Европ, 32.6 хувь нь Зүүн Ази, Номхон Далайн бүс нутаг, 5.2 хувь нь Америк, 7.5 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 36.3 хувийг ОХУ-ын иргэд, 19.2 хувийг БНХАУ-ын иргэд, 11.5 хувийг Беларусь, 6.7 хувийг БНСУ-ын иргэд, 4.5 хувийг АНУ-ын иргэд, 2.1 хувийг Казахстан улсын иргэд, 19.7 хувийг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.

Манай улсын 282.2 (давхардсан тоогоор) мянган иргэн 2021 онд гадаадад зорчсоноос 120.9 (42.8%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор зорчсон нь өмнөх оноос 148.0 (55.1%) мянгаар, 161.3 (57.2%) мянга нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор зорчсон нь өмнөх оноос 141.6 (46.7%) мянгаар тус тус буурчээ.


ХҮСНЭГТ 2. ГАДААДАД ЗОРЧСОН МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, улсаар, жил бүрийн эцсийн байдлаар

Зорчсон улсын нэр	2018	2019	2020	2021
БНХАУ	1 849 778	1 791 374	467 076	224 368
ОХУ	356 970	344 267	48 402	12 222
БНСУ	99 217	97 017	18 571	9 542
Япон	25 313	27 953	6 380	2 365
АНУ	14 554	15 987	2 432	5 690

Гадаадад зорчсон Монгол Улсын иргэдийн 254.4 (90.2%) мянга нь эрэгтэйчүүд, 27.8 (9.8%) мянга нь эмэгтэйчүүд, 276.8 мянга (98.1%) нь насанд хүрсэн иргэн, 5.4 мянга (1.9%) нь хүүхэд байна. Тэдний 262.6 (93.0%) мянга нь 30 хүртэл хоног, 2.3 мянга (0.8%) нь 30-аас 90 хүртэл хоног, 17.3 (6.2%) мянга нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар явсан байна.

Улсын хилээр 2021 онд 1 404.2 (давхардсан тоогоор) мянган тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн нь өмнөх оноос 354.2 (20.1%) мянгаар буурчээ. Тэдгээрийн 66.6 хувийг ачааны вагон, 31.4 хувийг ачааны машин, 0.1 хувийг суудлын машин, 1.9 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна. Нийт тээврийн хэрэгслийн 56.3 хувь нь Замын-Үүд, 11.4 хувь нь Гашуун сухайт, 16.0 хувь нь Сүхбаатар, 5.5 хувь нь Шивээ хүрэн, 1.8 хувь нь Алтанбулаг, 9.0 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрсэн байна.

ЗУРАГ 2. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, дүнд эзлэх хувиар, боомтын төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар



Аргачлалын тайлбар:

Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдод гадаадын болон дотоодын иргэдийг хамруулав. Монгол Улсын хилээр орсон зорчигчдыг зорилгоор нь албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, суралцах, ажиллах, байнга оршин суух, бусад гэж ангилна.

Жуулчин: Байнга оршин суудаг газраасаа өөр газарт албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, бусад зорилгоор 183 хоногоос доош хугацаагаар аялж буй гадаадын иргэн юм.



Эх үүсвэр:

Хил Хамгаалах Ерөнхий Газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Тооллого, өгөгдлийн шинжилгээний
газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч Ш.Ариунболд
Утас : (976-51)-26 1523

Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын
Хүн ам, орон сууцны тооллогын хэлтсийн
статистикч Ж.Цогзолмаа
Утас : (976-51)-267547

